

**БАТЛАВ.**  
**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ**  
**ГАЗРЫН ДАРГА**

**Э.БАТТУЛГА**

**ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ**

2026 оны 05 дугаар сарын 11 өдөр

Дугаар 2026/УУЧ-16

Улаанбаатар хот

Энэхүү Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зардлын тооцоо гаргах зөвлөх үйлчилгээний гэрээ /цаашид “Гэрээ” гэх/-г Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйл болон холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэн нэг талаас Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Цаг уур, орчны шинжилгээний газар /цаашид “Захиалагч” гэх/, нөгөө талаас Макро эдийн засаг ба эрүүл мэнд ТББ /цаашид “Гүйцэтгэгч” гэх/ -ийг төлөөлж Тэргүүн Д.Чимэддагва нар дор дурдсан нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1 Энэхүү гэрээгээр зөвлөх үйлчилгээг гүйцэтгүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих, тайлан хүлээн авах, төлбөр төлөхтэй холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2 Захиалагч нь гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлбөрийг олгох бөгөөд Гүйцэтгэгч нь гэрээний үүргийг хугацаанд нь бүрэн биелүүлж, тайланг хүлээлгэн өгнө.

**ХОЁР. ГЭРЭЭНИЙ ҮНЭ**

- 2.1 Гэрээний нийт төлбөр 13,600,000 /арван гурван сая зургаан зуун мянган/ төгрөг байна. Үүнд татвар, шимтгэл болон бусад зардал багтсан болно.
- 2.2 Төлбөрийг ажлын үр дүнг бүрэн хүлээн авч, акт үйлдсэний дараа Худалдаа хөгжлийн банкны MN110004000404201380 тоот дансанд 100 хувь олгоно.

**ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА**

- 3.1 Ажлыг гэрээ байгуулсан өдрөөс хойш ажлын 15 хоногийн дотор бүрэн гүйцэтгэнэ.
- 3.2 Гүйцэтгэгч нь ажлын төлөвлөгөөг гарган гэрээний хавсралтаар баталгаажуулна.

**ДӨРӨВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ**

- 4.1 Захиалагчийн эрх, үүрэг:
  - 4.1.1 Гүйцэтгэгчээс гэрээний үүргээ биелүүлэхийг шаардах;
  - 4.1.2 Ажлын гүйцэтгэлд хяналт тавих;
  - 4.1.3 Шаардлагатай мэдээлэл, баримт бичгээр хангах;
  - 4.1.4 Гүйцэтгэлийг хугацаанд нь хүлээн авах.
- 4.2 Гүйцэтгэгчийн эрх, үүрэг:
  - 4.2.1 Ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэх;
  - 4.2.2 Эцсийн тайланг Word, PDF болон хэвлэмэл 1 хувь хэлбэрээр хүргүүлэх;
  - 4.2.3 Захиалагчийн өгсөн зөвлөмжийг харгалзан ажиллах;
  - 4.2.4 Захиалагчид мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх.

**ТАВ. ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА**

5.1 Гүйцэтгэгч гэрээнд заасан хугацаанд ажлыг бүрэн дуусгаагүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй ажлын үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алданги төлнө.

5.2 Захиалагч тайланг ажлын 3 хоногийн дотор үнэлж, дүгнэнэ.

5.3 Захиалагч хугацаанд нь үнэлгээ, дүгнэлт гаргаагүй бол ажлыг хүлээн авсанд тооцно.

### **ЗУРГАА. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ**

6.1 Маргааныг харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ.

6.2 Зөвшилцлөөр шийдвэрлэж чадаагүй бол Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

### **ДОЛОО. БУСАД ЗҮЙЛ**

7.1 Гэрээ нь талууд гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

7.2 Гэрээг 2 хувь үйлдэж талууд тус бүр 1 хувийг хадгална.

7.3 Ажлын даалгавар нь гэрээний салшгүй хэсэг болно.

### **НАЙМ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ**

8.1 Давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээний үүргийг биелүүлэх боломжгүй болсон бол хугацааг тухайн нөхцөл байдал арилтал хойшлуулна.

### **ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

#### **ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ**

ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА



Ш.ЦЭРЭНДУЛАМ

Хаяг: Улаанбаатар-15160  
Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Жуулчны  
гудамж-5, Бага тойруу-3

Утас: 51- 264857

#### **ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ**

МАКРО ЭДИЙН ЗАСАГ БА ЭРҮҮЛ МЭНД

ТББ ТЭРГҮҮН



Д.ЧИМЭДДАГВА

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй  
дүүрэг, 4-р хороо, байр-18, 57 тоот

Утас: 94076661

**УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ /Шинэчилсэн  
найруулга/-ИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

Хуулийн төсөл санаачлан

боловсруулагч:

Цаг уур, орчны шинжилгээний газар

Гэрээний дугаар:

2026/ЦУ-16

Гүйцэтгэгчийн нэр:

"МЭЗЭМ" ТББ

Судалгааг хүлээлгэн өгсөн

огноо:

2026.05.28



*Урва* ) *Д. Умарзугаева*

## Товчилсон үг, үгийн тайлбар

УЦУОХШ	Ус цаг уур, орчны хяналт шинжилгээ
Хуулийн төсөл	Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл
Аргачлал	Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”

## Ерөнхий зүйл

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын хамтарсан тушаалаар Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг 2026 оны 04 дугаар сарын 20-ний өдөр баталжээ. 1997 онд анхдагч хууль баталсанаас хойш өнгөрсөн 30 шахам жилийн хугацаанд нийгэм, эдийн засаг, шинжлэх ухааны технологийн дэвшлийн хүрээнд гарсан дэвшил, өөрчлөлтөд нийцүүлэн УЦУОХШ-ний ажлын цар хүрээг өргөжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн явц байдлыг хянах, үнэлэх, эрсдлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлэх, шинжлэх ухаан, технологийн ололтыг нэвтрүүлэх, зах зээлийн харилцааны зарчимд нийцүүлэх, байгаль орчны төлөв байдлын бодит байдал, эрсдлийг үнэлэх, урьдчилан сэргийлэх, УЦУОХШ-ний албаны бүтэц, зохион байгуулалтын нэгдмэл байдлыг хангах, албаны ажилтны салбарын онцлогт нийцсэн цалин, нийгмийн баталгааны чиглэлээр өргөн хүрээтэй асуудлыг тусгах хэрэгцээ шаардлага тулгарч, шинэчлэн найруулсан хуулийн төслийг боловруулжээ.

Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагуудад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах, зардлыг бууруулах талаар санал боловсруулахад энэхүү тайлан чиглэгдэнэ.

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийхэд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ыг баримталсан.<sup>1</sup>

Хуулийн төслийн зардлыг тооцохдоо бодит статистик болон хугацааг шууд ашиглах боломжгүй тохиолдолд аргачлалын 2.5.2 дугаар зүйлд “Тохиолдлын тоо нь тухайн үүргийг хэдэн хуулийн этгээдэд хүлээлгэж байгааг илэрхийлнэ. Ингэхдээ статистикийн тоо мэдээг ашиглах бөгөөд энэ талаар статистик тоо мэдээ байхгүй бол баримжаалж тооцно.” гэж заасан болон 4.4.2 дугаар зүйлд “Зарцуулах хугацааг тодорхойлохдоо бусад төрийн байгууллагад адил төстэй үйлчилгээ байгаа эсэхийг судалж холбогдох мэргэжилтнүүдийн саналыг авах бөгөөд тэдгээрийн гүйцэтгэсэн

<sup>1</sup> Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”

ажил, үйлчилгээгээр баримжаалж тогтооно.” гэж тус тус заасныг үндэслэн адил төстэй ажил, үйлчилгээ байгаа эсэхийг судалж, тухайн салбарын мэргэжилтний мэдээлэл, саналыг баримтлан баримжаалах зэргээр хугацаа, тохиолдлын тоо зэргийг тогтоосон болно.

Түүнчлэн, зардлын тооцоог хийхэд нийтэд ил болгосон мэдээлэл болон холбогдох байгууллагаас авсан албан ёсны тоон мэдээллийг ашигласан хэдий ч зардлын тооцоонд ашигласан мөнгөн дүн, үнэ нь зөвхөн гарах зардалд баримжаа өгөх зорилготой тул хууль батлагдсаны дараа хуулийг хэрэгжүүлэхэд бодитоор гарах зардлаас ялгаатай байх боломжтой юм.

### **Үнэлгээний хамрах хүрээ**

Зардлын тооцооны тайланд хуулийн төслийн харилцаанд оролцогч гол байгууллагууд, зардалд нөлөө бүхий зохицуулалтуудыг сонгож, шинээр зардал шаардах эсэхийг авч үзсэн.

Хуулийн төслөөс сонгон зардал тооцох зохицуулалт буюу үнэлгээний хүрээний тухайд Аргачлалын дагуу иргэн, хуулийн этгээдэд шинээр үүссэн үүрэг, харилцаанаас үүсэх зардал, ачааллыг тооцох буюу өмнө байсан харилцааг зохицуулсан зохицуулалтад өөрчлөлт ороогүй зардал, ачааллыг тооцдоггүй. Төрийн байгууллагын хувьд өмнө нь хэрэгжүүлж байсан чиг үүрэгт өөрчлөлт ороогүй бол мөн зардал тооцохгүй бөгөөд хуулийн төсөлд хамаарах үндсэн хэрэгжүүлэгч агентлагт үүсэх ачаалал болон улсын төсөвт их хэмжээгээр үүсгэх зардлыг голчлон тооцох зарчмыг баримтална гэснийг мөрдлөг болгов.

Дээр дурдсаныг үндэслэн дараах байдлаар зардал тооцох үнэлгээний хүрээг тодорхойлов:

1. Цаг уур, орчны шинжилгээний байгууллага тусгай хэрэгцээний, төрөлжсөн мэдээллийн төлбөртэй үйлчилгээ үзүүлснээр тухайн байгууллагын төсвийн нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэхийн зэрэгцээ уг үйлчилгээг авах иргэн, хуулийн этгээдэд шууд бус зардал үүснэ.
2. УЦУОХШ-ний салбарын ажилтны цалин хангамж, нийгмийн баталгаатай холбоотой төрийн байгууллагад зардал үүснэ.
3. Хуулийн төслийг хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн зохицуулалттай харьцуулахад УЦУОХШ-ний ажлын хүрээнд хийгдэх ажлын төрөл, хамрах

хүрээ өргөжсөн байх ба тэдгээр нь төрийн байгууллагад зардал шаардсан шинэ чиг үүргийг бий болгосон эсэхийг нягтлан үзэхэд дараах үндэслэлээр нэмэлт зардал шаардахгүй болохыг тогтоов:

3.1 Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд нэрлэн заагаагүй хэдий ч одоо хэрэгжиж буй ажил үйлчилгээг хуулийн төсөлд нарийвчлан тодорхойлсон;

3.2 Шинээр тусгасан чиг үүрэг нь одоогийн хуульд заасан үүргийн хүрээнд агуулгаараа багтсан;

3.3 Батлагдсан хүний нөөц, төсвийн хүрээнд хэрэгжүүлэх боломжтой;

3.4 Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүтэц, зохион байгууллалтын өөрчлөлтөөр түүний харьяа байгууллагын нэр өөрчлөгдсөн ба чиг үүрэгт зарчмын өөрчлөлт ороогүй

Хуулийн төслөөр зохицуулах зардалд нэмэлт төсөв шаардлагатай, голлон нөлөө үзүүлэх доорх зүйл, хэсэг, заалтыг сонгон авч зардал, ачааллыг тооцов. Үүнд:

#### **Нэг. Хуулийн этгээдэд шинээр үүсэх зардал, ачаалал**

Энэ хэсэгт тухайн хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдийн эрхлэх үйл ажиллагаатай холбоотой гүйцэтгэх үүргийн улмаас үүсэх зардлыг мөнгөн дүнгээр тооцоолон гаргана. Ийнхүү үүсэх зардлыг Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолно. Үүнд:

- ✓ Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- ✓ Хуулийн этгээдийн зардлыг тооцох;
- ✓ Хуулийн этгээдийн зардлын тоон үзүүлэлтийг тооцох;
- ✓ Нийт зардлын дүнг тооцож гаргах;
- ✓ Хялбарчлах буюу зардлыг бууруулах боломжийг шалгах;
- ✓ Хуулийн этгээдийн нэмэлт зардлыг тооцох;

Хуулийн төслийн хүрээнд хуулийн этгээдэд ямар ямар үүргийг шинээр бий болгож байгааг тодорхойлж, уг үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай баримт бичгийн агуулгыг тодорхойлсны үндсэн дээр зардлын тооцоог хийх болно.

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлалын 2.2-т “Хуулийн этгээдийн хувьд хууль тогтоомжид заасан үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан гарах мөнгөн зардлыг тооцно.” гэж заасан.

Хуулийн төсөлд хуулийн этгээдэд үүрэг бий болгож болзошгүй дараах зохицуулалт тусгагдсан байна. Үүнд:

№	Хуулийн төслийн зүйл заалтын дугаар	Зохицуулалт
1.	Хуулийн төслийн 26 дугаар зүйл	<p>26.1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах үйлчилгээг үзүүлнэ:</p> <p>26.1.1. нийтийн хэрэгцээний мэдээгээр хэрэглэгчийг хангах;</p> <p>26.1.2. тусгай хэрэгцээний мэдээгээр хангах;</p> <p>26.1.3. агаарын төлөв байдал, цаг агаарт зориудаар нөлөөлөх;</p> <p>26.1.4. нисэхийн цаг уурын үйлчилгээ;</p> <p>26.1.5. хэмжилт, ажиглалтын багаж хэрэгслийг баталгаажуулах;</p> <p>26.1.6. орчны чанарын хяналт шинжилгээ үйлчилгээ;</p> <p>26.1.7. уур амьсгалын мэдээллийн үйлчилгээ;</p> <p>26.1.8. хөдөө аж ахуйн цаг уурын үйлчилгээ;</p> <p>26.1.9. Хиймэл дагуулын мэдээний үйлчилгээ</p> <p>26.3. Энэ хуулийн 26.1.2-26.1.9-д заасан үйлчилгээг хэрэглэгчийн хүсэлтэд үндэслэн төлбөртэй үзүүлнэ. Үйлчилгээний төлбөрийн хэмжээг холбогдох хуулиар эрх олгосон Засгийн газрын гишүүн батална.</p>

2.	Хуулийн төслийн 15.1, 15.3	<p>15.1. Хэрэглэгч нэгдсэн сан, архивын мэдээллийг энэ хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу ашиглаж болно.</p> <p>15.3. Нэгдсэн сан, архивын баримтаас лавлагаа, мэдээлэл авахад үйлчилгээний хөлс төлнө. Үйлчилгээний хөлсийг хуулиар эрх олгосон байгууллага батална.</p>
4	Хуулийн төслийн 15.2	<p>15.2. Хэрэглэгчийн ашиглаж буй ус цаг уур, уур амьсгал, орчны мэдээ, мэдээллийн эх сурвалж нь тодорхой байх бөгөөд ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага баталгаажуулсан байна.</p>

Дээрх хүснэгтээс харахад:

1. Аж ахуйн нэгж цаг уур, орчны шинжилгээний чиглэлээр гаргах мэдээ, мэдээлэл болон ашиглаж буй ажиглалт, хэмжилтийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжид эрх бүхий байгууллагаар баталгаажуулалт хийлгэх үүрэгтэй холбоотойгоор тодорхой хэмжээний зардал гарах боломжтой.

Гэвч энэхүү харилцаа нь хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиар өмнө нь зохицуулагдсан харилцаа хэвээр байна.

Хүчинтэй хуулийн заалтын дагуу тус газрын харьяа байгууллага болох Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори нь УЦУОХШ-ний улсын сүлжээний багаж, хэрэгслийг баталгаажуулах, өөрийн эталон багажуудыг олон улсад баталгаажуулж иргэн, аж ахуйн нэгжийн багаж, хэрэгслийн баталгаажуулах ажлыг гүйцэтгэж байна. Тухайлбал 2025 онд тухайн байгууллага нь жилдээ 340,0 гаруй сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна. Үүнээс 821 иргэн, аж ахуйн нэгжийн байгаль орчны хяналт-шинжилгээтэй холбоотой үйлчилгээнээс 16.8 сая төгрөг, 1184 иргэн, аж ахуйн нэгжийн багаж, хэрэгслийг баталгаажуулснаас 329.6 сая төгрөгийн орлого тус тус төвлөрүүлжээ. Энэхүү орлого нь шадар сайдын шинээр баталсан тариф, үнэ хөлсийг баримтлан үйлчилгээ үзүүлсэн бөгөөд тухайн үйлчилгээний хөлсийг нэр төрөл, хамрах хүрээ, хугацаа зэргийг харгалзан тогтоодог. Гэвч 2025 онд

зарим баталгаажуулалтын төлбөр нь баталгаажуулж буй багаж, хэрэгслийн үнээс 3-5 дахин үнэтэй тогтоогдсон нь аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн дарамт учруулж байна гэх гомдол, санал гарсан байна.

Уг хуулийн төсөлд дээрх харилцааг зохицуулсан зохицуулалт үндсэндээ хэвээр хадгалагдсан байна. Харин үйлчилгээний үнэ, тарифын талаар гомдол, санал ирүүлсэн тохиолдолд эрх бүхий Засгийн газрын гишүүн холбогдох тариф, үнэ хөлсийг өөрчлөх боломжтой гэж үзэж байна. Иймд уг асуудлаар тусгайлан нэмэлт тооцоо хийх шаардлагагүй гэж үзлээ.

2. Архив, мэдээллийн сангаас иргэн, хуулийн этгээд үйлчилгээг төлбөртэй үзүүлэх үйлчилгээ одоогийн хуулиар хэрэгжиж байгаа зохицуулалт тул энэ үйлчилгээ авахад зардлын тооцоо хийхийг шаардахгүй.

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулиар төрийн, байгууллагын, хувь хүний гэсэн төрөлтэй байдаг бөгөөд цаг уурын архив нь төрийн төрөлжсөн архивт хамаардаг байна. Иймд хуульд “Архивын баримтыг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах нийтлэг журам, архиваас үзүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээг архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална” гэж заасны дагуу 2023 онд батлагдсан “Төрийн архиваас үзүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээ”-г тогтоосон ба үйлчилгээний нэр, төрөл, хэмжих нэгжээс хамаарч 100 төгрөгөөс 20000 төгрөг хүртэлх тарифаар иргэн, аж ахуйн нэгжид үйлчилгээ үзүүлж байна. Уг үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд үзүүлснээр 2024 онд 345 хэрэглэгч 65.0 сая төгрөг, 2025 онд 666 хэрэглэгч 71.8 сая төгрөг, 2026 оны 4 сарын байдлаар 268 хэрэглэгч 39,6 сая төгрөгийн үйлчилгээний хөлс төлсөн байна.

Хуулийн төсөлд архив, мэдээллийн санг шинээр бүлэг болгон хуульчилсан бөгөөд мэдээллийн санг бие даасан ус цаг уур, орчин, уур амьсгалын мэдээ мэдээллээр баяжуулан тодорхойлж, мэдээллийн сангийн үйлчилгээг цахимжуулах, хадгалалт хамгаалалт, хөгжүүлэлтийг хийх талаар тодорхой хуульчлан өгсөн байна. Хүчин төгөлдөр хуулийн хүрээнд архивын газрын даргын баталсан тарифаар үйлчилгээг үзүүлж байгаа харилцааг зохицуулсан зохицуулалт хэвээр хадгалагдсан байна. Харин үйлчилгээний үнэ, тарифын талаар гомдол, санал ирүүлсэн тохиолдол байхгүй байна.

Хуулийн 27.2 дугаар зүйлд “ Энэ хуулийн 27.1-д заасан энгийн зөвшөөрлийг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага таван жилийн хугацаагаар олгоно.” гэж заасан. Хувийн цаг уурын үйлчилгээ хүчинтэй хуулинд байсан заалт бөгөөд 29 жил болоход ямар ч байгууллага, иргэн хүсэлт гаргаагүй бөгөөд одоо байгаа хуулийн өмнөх шигээ энгийн эрхээр хийхээр хуульчилсан. Энэ нь аж ахуйн нэгжид хураамжийн төлбөрөөс өөр зардал гарахгүй, ямар тоног төрөөхөмж авч хэрэглэх нь тухай этгээдийн өмч хэвээрээ байх болохоор тусгайлан тооцоо хийхгүй болно.

Хуулийн төсөлд энэ харилцаа шинээр үүссэн иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх ачаалал бага уг асуудлаар тусгайлан нэмэлт тооцоо хийх шаардлагагүй гэж үзлээ.

#### **Хоёр. Иргэнд шинээр үүсэх зардал, ачаалал**

Хуулийн төсөлд иргэнд шууд үүрэг болгосон заалт байхгүй. Харин иргэнд шууд бусаар зардал үүсгэж болзошгүй гэж дараах зохицуулалтууд тусгагдсан. Үүнд:

№	Хуулийн төслийн зүйл, заалтын дугаар	Зохицуулалт
1	Хуулийн төслийн 26 дугаар зүйл	<p>26.1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах үйлчилгээг үзүүлнэ:</p> <p>26.1.1. нийтийн хэрэгцээний мэдээгээр хэрэглэгчийг хангах;</p> <p>26.1.2. тусгай хэрэгцээний мэдээгээр хангах;</p> <p>26.1.3. агаарын төлөв байдал, цаг агаарт зориудаар нөлөөлөх;</p> <p>26.1.4. нисэхийн цаг уурын үйлчилгээ;</p> <p>26.1.5. хэмжилт, ажиглалтын багаж хэрэгслийг баталгаажуулах;</p> <p>26.1.6. орчны чанарын хяналт шинжилгээ үйлчилгээ;</p> <p>26.1.7. уур амьсгалын мэдээллийн үйлчилгээ;</p>

		<p>26.1.8. хөдөө аж ахуйн цаг уурын үйлчилгээ;</p> <p>26.1.9. Хиймэл дагуулын мэдээний үйлчилгээ</p> <p>26.3. Энэ хуулийн 26.1.2-26.1.9-д заасан үйлчилгээг хэрэглэгчийн хүсэлтэд үндэслэн төлбөртэй үзүүлнэ. Үйлчилгээний төлбөрийн хэмжээг холбогдох хуулиар эрх олгосон Засгийн газрын гишүүн батална.</p>
2	Хуулийн төслийн 15.1, 15.3	<p>15.1. Хэрэглэгч нэгдсэн сан, архивын мэдээллийг энэ хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу ашиглаж болно.</p> <p>15.3. Нэгдсэн сан, архивын баримтаас лавлагаа, мэдээлэл авахад үйлчилгээний хөлс төлнө. Үйлчилгээний хөлсийг хуулиар эрх олгосон байгууллага батална.</p>

Ус цаг уур, орчны хяналт шинжилгээ, ажиглалт, хэмжилтийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжид баталгаажуулалт хийх үйлчилгээ, Архивын болон мэдээллийн сангаас мэдээ, мэдээллээр иргэн, хуулийн этгээд үзүүлж буй үйлчилгээ одоогийн хуулиар хэрэгжиж байгаа зохицуулалт тул энэ үйлчилгээ авахад зардлын тооцоо хийх шаардлагүй, шинээр ачаалал үүсэх, төсвийн орлогод нөлөөлөхгүй гэж үзлээ.

### **Гурав. Төрийн байгууллагад шинээр үүсэх зардал**

Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолно. Үүнд:

- ✓ Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох;
- ✓ Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;
- ✓ Гарах зардлыг урьдчилан тооцох;
- ✓ Зардлыг нэгтгэн тооцох;
- ✓ Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах;

Хуулийн төсөлд төрийн байгууллагад зардал үүсгэх, төсөвт нөлөө үзүүлэх дараах зохицуулалтууд тусгагдсан байна. Үүнд:

1	Хуулийн төслийн 24.1.1	24.1.1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний албанд тасралтгүй 5 болон түүнээс дээш жил ажиллаж байгаа мэргэжилийн ажилтанд тав дахь жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг олгоно. Тэтгэмж олгохтой холбоотой журмыг Засгийн газар батална;
2	Хуулийн төслийн 24.1.2	24.1.2. Ус цаг агаар, орчны онц аюултай үзэгдэлтэй, амь нас, эрүүл мэнд хохирох өндөр эрсдэлтэй үед ажилласан ажилтанд ажилласан хугацааны цалин хөлсийг нь гурав дахин нэмэгдүүлж олгох;
3	Хуулийн төслийн 24.1.4	24.1.4. Хөдөлмөрийн хортой, аюултай хүчин зүйлийн үйлчлэл болон тэдгээртэй адилтгах эрсдэлтэй ажлын байранд ажиллаж байгаа ажилтанг тусгай зориулалтын хувцас, багаж хэрэгслээр хангах, ажилтанд мөнгөн урамшуулал олгох, түүнийг олгохтой холбоотой журмыг Засгийн газар батална;

**24.1.1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний албанд тасралтгүй 5 болон түүнээс дээш жил ажиллаж байгаа мэргэжилийн ажилтанд тав дахь жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг олгоно. Тэтгэмж олгохтой холбоотой журмыг Засгийн газар батална;**

УЦУОХШ- ний салбарын нийт 26 байгууллагын 1,722 ажилтны хүний нөөц болон цалингийн нэгдсэн мэдээлэлд үндэслэн тооцооллыг хийсэн. Төрийн албанд

ажилласан жилээр бүлэглэж үзэхэд хамгийн их хувийн жинг 5–10 жил ажилласан ажилтнууд эзэлж байна (380 хүн, 22.1 хувь). Дараагаар нь 10–15 жил (287 хүн, 16.7 хувь), 15–20 жил (259 хүн, 15.0 хувь), 5-аас доош жил (222 хүн, 12.9 хувь), 20–25 жил (213 хүн, 12.4 хувь) ажилласан бүлэг орж байна. 35–40 жил ажилласан туршлагатай ажилтнууд хамгийн цөөн буюу нийт 63 хүн (3.7 хувь) байна.

Зураг-1 Хүний тоо, төрийн албанд ажилсан жилийн харьцаа



Эх үүсвэр: Цаг уур, орчны шинжилгээний газар

Тус салбарт ажиллагсдын үндсэн цалинг ажилсан жилээр бүлэглэж тооцоход сарын дундаж цалин 1 351 680 -1 446 825 төгрөг байна. Салбарын сарын дундаж үндсэн цалин 1 398 007 төгрөг байна.

Хүснэгт-1 Хүний тоо болон дундаж цалин

Төрийн албанд ажилласан жил	Хүний тоо	Дундаж цалин	Хувийн жин
5-аас доош	222	1,351,680	12.9%
5-10	380	1,376,376	22.1%
10-15	287	1,407,294	16.7%
15-20	259	1,410,668	15.0%
20-25	213	1,419,268	12.4%
25-30	191	1,406,058	11.1%
30-35	107	1,429,944	6.2%
35-40	63	1,446,825	3.7%
<b>Нийт</b>	<b>1,722</b>	<b>1,398,007</b>	<b>100.0%</b>

Энэхүү мэдээлэлд үндэслэн хуулийн шинэ заалтын хүрээнд Салбартаа тасралтгүй 5 болон түүнээс дээш жил ажиллаж байгаа ажилтанд тав дахь жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн тэтгэмж олгох заалтын дагуу тооцоолол хийхэд салбарын түвшинд 10 тэрбум 318 сая төгрөг шаардагдахаар байна. Харин дараагийн жилүүдийн нэмэлт санхүүжилт харьцангуй бага байхаар байна.

Хүснэгт-2. Зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн тэтгэмж олгохтой холбоотой тооцоолол

	2027	2028	2029	2030	2031	2032	Нийт дүн
Булган аймгийн УЦУОШТ	559,777	8,082					567,859
Говьсүмбэр аймгийн УЦУОШТ	70,502		8,904	27,630			107,036
Дорнод аймгийн УЦУОШТ	459,396	24,648					484,044
Завхан аймгийн УЦУОШТ	309,528	64,656	32,328		16,164		422,676
НИСЛЭГИЙН ЦАГ УУРЫН ТӨВ	304,812	23,562		16,968	8,484		353,826
Цаг уур, орчны шинжилгээний газар	519,066	19,524	8,904				547,494
Архангай аймгийн УЦУОШТ	431,748	8,082	16,164	8,082			464,076
БОХЗТ ЛАБОРАТОРИ	177,450						177,450
Говь-Алтай аймгийн УЦУОШТ	451,730	16,164	8,082		16,164	32,730	524,870
Дундговь аймгийн УЦУОШТ	361,620	32,328	16,164	8,082			418,194
Орхон аймгийн УЦУОШТ	85,074	32,064	8,904				126,042
Өвөрхангай аймгийн УЦУОШТ	525,960	8,484	54,216	16,164	22,896		627,720
Хөвсгөл аймгийн УЦУОШТ	751,554	64,656	40,410	16,164			872,784
Сүхбаатар аймгийн УЦУОШТ	264,426	15,396	6,312	8,082			294,216
Баянхонгор аймгийн УЦУОШТ	407,340	38,052	64,656	81,222	8,082		599,352
Ховд аймгийн УЦУОШТ	623,151	24,246	16,164	16,164	8,082		687,807
Дархан-Уул аймгийн УЦУОШТ	185,562	30,372		8,082			224,016
Баян-өлгий аймгийн УЦУОШТ	525,762	8,082	13,806				547,650
Улаанбаатар УЦУОШТ	226,302		48,492	24,246			299,040
Увс аймгийн УЦУОШТ	603,406	16,164	8,082	8,082			635,734
Сэлэнгэ аймгийн УЦУОШТ	348,936	56,574	40,410				445,920
Дорноговь аймгийн УЦУОШТ	337,476	16,164	24,246	8,082	16,164		402,132
Хэнтий аймгийн УЦУОШТ	448,046	16,164	40,812	32,286		24,246	561,554
Төв аймгийн УЦУОШТ	546,192	74,400	46,956	9,300			676,848
УЦУОСМ Хүрээлэн	402,505	16,968	48,144	68,292			535,909
Өмнөговь аймгийн УЦУОШТ	391,410	8,082	40,410	24,246	17,436		481,584
Grand Total	10,318,729	623	593	381	113	57	12,085,831

УЦУОХШ-ний салбарын албан хаагчид нарийн мэргэжлийн илүү тогтвортой, хөрвөх боломж хязгаарлагдмал, удаан хугацаанд салбартаа ажилласан байгаа нь салбарын онцлог бөгөөд эхний жилдээ төсөвт ирэх ачаалал дараагийн жилээс 2 дахин буурч, ирэх 5 жилд 10 дахин буурахаар байна. (Холбогдох задаргаа тооцоог Excel дээр хүлээлгэж өгөв)

**24.1.2. Ус цаг агаар, орчны онц аюултай үзэгдэлтэй, амь нас, эрүүл мэнд хохирох өндөр эрсдэлтэй үед ажилласан ажилтанд ажилласан хугацааны цалин хөлсийг нь гурав дахин нэмэгдүүлж олгох;**

2024 нийт 104 удаагийн цаг агаарын гаралтай аюулт болон гамшигт үзэгдэл болсон байна. Монгол орныг хамарсан үзэгдэл 2 удаа болсон байна. 2025 онд улсын хэмжээнд нийт 73 удаагийн цаг агаарын гаралтай аюулт болон гамшигт үзэгдэл болсон байна. Монгол орныг хамарсан үзэгдэл 2 удаа тохиолдсон. Дээрх 2 жилийн дунджаар авч үзэхэд жилд дунджаар 350 орчим хүн 3 цаг ажилсан байна. Энэхүү мэдээлэлд суурилан тооцоолол хийхэд ойролцоогоор 25 164 888 төгрөг болохоор байна.

Хүснэгт-3 Цалин хөлсийг нэмэгдүүлэх тооцоолол

Сарын дундаж цалин	1,406,038
Өдөрт	63,911
Цагт	7,989
Дунджаар 3 цаг	23,967
Ажилсан хүний тоо	350
Нийт урамшуулал	8,388,296
3 дахин нэмэгдүүлж олгох	25,164,888

**24.1.4. Хөдөлмөрийн хортой, аюултай хүчин зүйлийн үйлчлэл болон тэдгээртэй адилтгах эрсдэлтэй ажлын байранд ажиллаж байгаа ажилтанг тусгай зориулалтын хувцас, багаж хэрэгслээр хангах, ажилтанд мөнгөн урамшуулал олгох, түүнийг олгохтой холбоотой журмыг Засгийн газар батална;**

Байгаль орчны хяналт шинжилгээний 22 лабораторид нийт 92 албан хаагч ажиллаж байгаагаас 85 нь эмэгтэй, 7 нь эрэгтэй, дээд боловсролтой 76, дунд боловсролтой 16 байна. Үүнээс 83 хүн химийн бодистой ажиллаж байна. Эдгээр хүмүүсийн нийт цалингийн сан сард 118 882 сая төгрөг, жилд 1 426 591 сая төгрөг болж байна. Төв, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг эдгээр байгаль орчны

шинжилгээний лабораториуд нь 2016 оны А/02 тоот тушаалаар баталсан “Хяналт шинжилгээний ажлын хөтөлбөр”-ийн хүрээнд ижил арга, аргачлал, стандартаар, ижил төрлийн химийн урвалж бодис ашиглан нэг цагт хяналт шинжилгээг хийж байна. Хяналт шинжилгээг нойтон химийн аргаар 102 төрлийн химийн бодис ашигладаг байна. Иймд Эрүүл мэндийн салбарын лаборатори (хорт бодис)-ийн ажиллагсдын нэмэгдэл урамшуулал 10-30 хувьтай жишин тооцоолол хийлээ. Энэ жишгээр 3 хувилбараа тооцож үзэхэд нийт урамшууллын хэмжээ 10 хувиар-142.7 сая төгрөг, 20 хувиар тооцоход 285.3 сая төгрөг, 30 хувиар тооцоход 428 сая төгрөг болохоор байна.

Нэгдсэн тооцоололд мөнгөн урамшууллыг 20 хувиар бодож 285 сая төгрөгөөр тусгав.

Хүснэгт-4. Хөдөлмөрийн хортой, аюултай хүчин зүйлийн үйлчлэл бүхий ажлын байранд ажиллаж байгаа ажилтны мөнгөн урамшууллын тооцоо

	Хүний тоо	Дундаж цалин	10%		20%		30%	
			Нийт урамшуулал-Сард	Нийт урамшуулал-Жилд	Нийт урамшуулал-Сард	Нийт урамшуулал-Жилд	Нийт урамшуулал-Сард	Нийт урамшуулал-Жилд
ТҮМ-7	1	1,561,962	156,196	1,874,354	312,392	3,748,709	468,589	5,623,063
ТҮМ-6	7	1,488,373	1,041,861	12,502,329	2,083,722	25,004,659	3,125,582	37,506,988
ТҮМ-5	72	1,431,118	10,304,050	123,648,596	20,608,099	247,297,193	30,912,149	370,945,789
ТҮМ -3	3	1,287,174	386,152	4,633,826	772,304	9,267,652	1,158,457	13,901,478
Нийт	83		11,888,259	142,659,106	23,776,518	285,318,212	35,664,777	427,977,319

Хуулийн төсөлд шинээр бий болсон төрийн байгууллагын зарим чиг үүргийг дараах шалтгаанаар нэмж зардал үүссэн гэж үзээгүй болно:

1. Аргачлалын зааснаар бодлогын шинжтэй чиг үүрэг, төсөл боловсруулах батлахтай холбоотой заалтыг зардал шаардахгүй гэж үздэг ба хуулийн төслийн 17, 18, 19, 20 дугаар зүйл Улсын Их Хурал, Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллага, нутгийн өөрөө, удирдах байгууллагын эрх үүрэгтэй холбоотой заалт үүнд хамаарна.
2. Хуулийн төсөлд шинээр чиг үүргийн заалтууд нэмэгдсэн ч эдгээр нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн дагуу хэрэгжиж байгаа, эрх бүхий субъектийн тогтоол, шийдвэрээр баталсан эрх зүйн актын дагуу хэрэгжиж байгаа, практикт хэвшсэн зохицуулалт байгаа, түүнчлэн төрийн байгууллагад үүрэг болгосон заалтууд нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа заалтын агуулгад багтсан, илүү тодорхой болгосон

3. Бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах хэдий ч шинээр зохион байгуулах алба, газар хэлтэс, нэгж албад хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагын үүргийг хамааран гүйцэтгэх үүрэг байгаа тул төсөл батлагдсанаар төрийн байгууллагад хүний нөөцийн нэмэлт хэрэгцээ шаардлага гарахгүй бөгөөд улмаар төрийн байгууллага, төсөвт нэмэлт зардал үүсэхгүй гэж тооцлоо.

Үүнд:

Хуулийн төслийн 6 дугаар зүйл.УЦУОХШ-ний улсын сүлжээ, 7 дугаар зүйл.Улсын сүлжээний ерөнхий төлөвлөгөө, 8.1.Улсын сүлжээний ажиглалтын станц нь үйл ажиллагааны хөтөлбөртэй байна., 9.4.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээнд шинэ техник, технологи, автомат багаж, хиймэл оюун ухаанд суурилсан арга, аргачлалыг нэвтрүүлэх, хүний оролцооны алдааг бууруулах, өгөгдлийн чанар, хүртээмжийг сайжруулах үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэн явуулна., 14.3. Нэгдсэн сангийн үйл ажиллагаа, бүрдүүлэлт, ашиглах асуудлыг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна., 14.4.Нэгдсэн сангийн өгөгдөл, мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмж, кибер аюулгүй байдлыг хангах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлнэ., 16 дугаар зүйл.Цаг агаарын төлөв байдалд зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа, 22 дугаар зүйл.УЦУОХШ-ний албаны тогтолцоо зэрэг хуулийн зохицуулалтууд хамаарна.

### **Ерөнхий дүгнэлт**

Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, түүнтэй уялдуулан боловсруулсан хуулийн төслийн шинэчилсэн зохицуулалтууд нь одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн зохицуулалтуудыг илүү боловсронгуй болгосон, нарийвчилсан агуулгатай байгаагаараа хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагад зардал үүсэхээр шинэ буюу нэмэлт үүрэг ногдуулаагүй байна.

Нөгөө талаас, үзэл баримтлалд дурдсанчлан хуулийн төслийн холбогдох зохицуулалтууд нь иргэний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, байгаль орчинд үүсэх нөлөөллийг бууруулах, иргэдийг мэдээлэл авах эрхээр хангах, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн байгууллагын ачааллыг зохистой

хуваарилах иргэн, хуулийн этгээдийн шууд болон шууд бус зардлыг бууруулан, цаашдаа эдийн засагт хэмнэлтийн үр нөлөө үзүүлнэ.

Хуулийн төсөл батлагдсанаар төрийн байгууллага, хуулийн этгээдэд шинээр хүний нөөцийн хэрэгцээ шаардлага гарахгүй, улмаар хүний нөөцтэй холбоотойгоор цалингийн зардал гарахгүй гэж үзлээ.

Хуулийн төсөлд тусгагдсан нэмэлт өөрчлөлтүүд нь ихэнхдээ тухайн зохицуулалтыг боловсронгуй болгосон, зарим нэмэлт үүрэг нь одоо мөрдөгдөж буй хуулийн зохицуулалтын зардлын хүрээнд үргэлжлүүлэн хэрэгжүүлж болох үүрэг байх тул хуулийн төсөл батлагдсанаар төсөвт ачаалал нэмэхгүй, төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдэд аливаа нэмэлт зардал гарахгүй гэж дүгнэж байна.

Төрийн байгууллагад үүсэх гол ачаалал нь салбарын ажилтны нийгмийн баталгаа хангахтай холбоотойгоор үүснэ.

#### Хүснэгт-5 Зардлын тооцоо-нэгтгэл

	Нийт дүн
Салбартаа тасралтгүй 5 болон түүнээс дээш жил ажиллаж байгаа ажилтанд тав дахь жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн тэтгэмж олгох; журмыг ЗГ батлана.	10,318,729
Ус цаг агаар, орчны онц аюултай үзэгдэлтэй үед ажилласан ажилтанд ажилласан хугацааны цалин хөлсийг нь гурав дахин нэмэгдүүлж олгох	25,419
Хөдөлмөрийн хортой, аюултай хүчин зүйлийн үйлчлэл бүхий ажлын байранд ажиллаж байгаа ажилтанд мөнгөн урамшуулал олгох.	285,318
Нийт дүн	10,629,466

Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний хуулийг анх батлан мөрдөж эхэлснээс хойш өнгөрсөн 30 орчим жилийн хугацаанд 6 удаагийн өөрчлөлт оруулсан байх ба тэдгээр нь бусад хуулийг дагалдан орсон цаг үеийн шинжтэй өөрчлөлтүүд байжээ. Дээрх хугацаанд нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, техник технологийн түвшинд томоохон өөрчлөлтүүд гарч, олон хамтын ажиллагаа өргөжин тэлэхийн хамт Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцоор хүлээх үүрэг өсөн нэмэгдэж байна.

Үндэсний болон салбарын бодлогын баримт бичгүүдэд хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэн, экосистемийн тэнцвэртэй байдлыг хангасан амьдралын орчинг бүрдүүлэх зорилтуудыг дэвшүүлсэн. Байгаль, орчин уур амьсгалын өөрчлөлт болон хүний хүчин зүйлийн нөлөөгөөр байгаль орчны тодорхойгүй эрсдэлт байдал өнөөдөр олон сорилтыг дагуулж байна.

Энэ хэрээр салбарын өмнө тавигдах шаардлага өсөн нэмэгдэхийн хэрээр гүйцэтгэх ажлын цар хүрээ өргөжин тэлж байна. Гэвч өнгөрсөн хугацаанд салбарын төсөвт дорвитой өөрчлөлт хийгдээгүй, ажилтны цалин, хангамжид цаг үеийн шаардлагад нийцсэн мэдэгдэхүйц өөрчлөлт ороогүй байна.

Салбарын үйл ажиллагааг шинэ шатанд гаргах, өөрчлөн зохион байгуулахад энэ удаагийн эрх зүйн шинэчлэл томоохон үүрэг гүйцэтгэхээр байна.

Зардлын үнэлгээгээр салбарын голлох үйл ажиллагаа нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн хүрээнд хэрэгжиж байгаа гэсэн үндэслэлээр нэмэлт зардал шаардахгүй гэж үзсэн хэдий ч салбарын жил жилийн төсөв боловсруулах, батлахад үйл ажиллагааны төсөв, ажилтны цалин хангамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн төсвийг шинэчлэлийг хийх шаардлага зүй ёсоор бий болжээ.

Тус салбарын 2025 оны төсвийн гүйцэтгэлээс харахад нийт зарлагын 80 гаруй хувийг цалин, хөлсний зардал эзэлж байгаа бөгөөд бараа үйлчилгээний зардал маш бага 6 хувийг эзэлж байна.

Хүснэгт-6 2025 оны төсвийн гүйцэтгэл, эзлэх хувь

Үзүүлэлт	2025	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	100.0%	100.0%
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	97.0%	95.0%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	97.0%	95.0%
Цалин хөлс болон нэмэгдэл суутгал	81.2%	78.9%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10.1%	9.9%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2.2%	2.1%
Хангамж, бараа материалын зардал	0.6%	0.6%
Нормативт зардал	0.2%	0.1%
Эд хогшил, урсгал засварын зардал	1.5%	1.6%
Томиллолт, зочны зардал	0.2%	0.3%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.9%	1.3%
Бараа үйлчилгээний бусад зардал	0.1%	0.2%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3.0%	3.7%

Судалгааны явцад томиллолт болон судалгаа шинжилгээний зардал дутмаг байгаагаас хэвийн үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй байдаг талаар хариуцсан ажилтнууд хэлж байсан. Тухайлбал: Зөвхөн бэлчээрийн даац, ургамал, цөлжилт, зудын эрсдэлийн үнэлгээг хийхэд Монгол орны бүх сум багийн 1556 цэгт жилд хамгийн багадаа 4-өөс доошгүй хийх хэрэгцээ шаардлагатай, төсвийн хүндрэлээс болоод улсын сүлжээг өргөтгөх ажил 10 жил хийгдээгүй тухайлбал агаар мандлын дээд давхарга судлан станц 7 байх ёстойгоос төсвийн хүндрэлээс болж хаасаар байгаад 2 үлдсэн, суурин радар 7-9 байхаас ганцхан тусламжийн радартай байна. Иймд тус салбарын төсвийн төлөвлөлтийг эргэж нягтлах сайжруулах шаардлагатай нь судалгааны явцад ажиглагдсан. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний байгууллагын үйл ажиллагаа нь ажлын ердийн цагийн горимоор хязгаарлагдахгүй, хоногийн 24 цаг, долоо хоногийн 7 өдөр тасралтгүй, байнгын бэлэн байдлаар ажилладаг. Гэвч өмнөх жилүүдэд хэрэгжүүлсэн орон тооны 10 хувийн цомхотголын улмаас ус цаг уур, орчны хяналт шинжилгээний байгууллагын хүний нөөцийн хүрэлцээ буурч, ялангуяа ээлжийн зохион байгуулалтаар ажилладаг нэгжүүдэд ажлын ачаалал эрс нэмэгдсэн байна. Тухайлбал, 24 цагийн тасралтгүй ажиллагаатай нэгжид 5 хүртэлх хүний бүрэлдэхүүнтэйгээр ээлжийн ажлыг зохион байгуулах нь ажилтан ээлжийн амралтаа эдлэх, өвчтэй, чөлөөтэй байх, сургалт, мэргэшүүлэх арга хэмжээнд хамрагдах, илүү цагийн ажлыг нөхөн амраах зэрэг хөдөлмөрийн хууль тогтоомжид заасан баталгааг бүрэн хангахад хүндрэл үүсгэж байна. Иймд Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг баталсантай холбогдуулан тус хуульд шинээр болон өргөжин нэмэгдсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, байгууллагын тасралтгүй ажиллагааг хангах, хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцсэн ээлжийн зохион байгуулалтыг бүрдүүлэх, ажилтны нийгмийн баталгаа, хөдөлмөрийн аюулгүй, зохистой нөхцөлийг хангах зорилгоор өмнө нь цомхотгосон орон тоог үе шаттай нөхөн нэмэгдүүлэх, шаардлагатай хүний нөөц, цалин хөлс, сургалт, мэргэшүүлэх арга хэмжээний санхүүжилтийг улсын төсөвт тусган шийдвэрлэх зайлшгүй хэрэгцээ, шаардлага үүсэж байна.

## Судалсан материалын жагсаалт

1. Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”
2. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл
3. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын 26 байгууллагын хүний нөөцийн цалин хөлсний дэлгэрэнгүй судалгаа
4. Байгууллагуудын бүтэц, орон тоог баталсан шийдвэрүүд
5. Салбарын 26 байгууллагын . Хөдөлмөрийн хортой, аюултай хүчин зүйлийн үйлчлэл болон тэдгээртэй адилтгах эрсдэлтэй ажлын байранд ажиллаж байгаа ажилтаны талаарх мэдээлэл
6. Давсан орлого түүний дэлгэрэнгүй судалгаа
7. Төлбөртэй үйлчилгээ үзүүлсэн хүчин төгөлдөр шийдвэр, тариф баталсан эрх зүйн актууд
8. 2025 онд үйлчилгээний хөлс авч төсөвт оруулсан орлого
9. Тухайн байгууллагын шинээр бий болгосон үйлчилгээний судалгаа, орон тоо, төсөв шаардлагатай чиг үүрэг нэмэгдсэн талаарх асуулга

ooOOoo

**“УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН  
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦОО  
БОЛОВСРУУЛАХ” ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ /01/12/ АЖЛЫГ ХҮЛЭЭН  
АВАХ АЖЛЫН ХЭСГИЙН АКТ**

2026 оны 06 сарын 09-ны өдөр

Дугаар:04/01

Улаанбаатар хот

**НЭГ.**

- 1.1 Гэрээний нэр: Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зардлын тооцоо боловсруулах зөвлөх үйлчилгээний ажил гүйцэтгэх  
Огноо: 2026 оны 06 сарын 09-ны өдөр;
- 1.2 Захиалагч: Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Цаг уур, орчны шинжилгээний газар
- 1.3 Зөвлөх үйлчилгээний ажлыг 2026 оны 06 сарын 09-ны өдөр бүрэн дуусаж, тайланг хүлээлгэн өгөв.
- 1.4 Зөвлөх үйлчилгээг хүлээн авах комиссын акт, холбогдох баримт бичиг, материалыг 2 хувь үйлдэв.
- 1.5 Энэ актаар хүлээн авсан зөвлөх үйлчилгээний бүх баримт бичиг нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
  - а) Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зардлын тооцооны тайлан

**ХОЁР.**

**2.1. Ажлын даалгаварын биелэлт**

Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуульд “Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зардлын тооцоо боловсруулах” зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу нийлүүлж буй зөвлөх үйлчилгээнийг ажлыг ЦУОШГ-ын даргын 2026 оны 03 дугаар сарын 26-ний өдрийн А/67 тоот тушаалаар томилогдсон хүлээн авах ажлын хэсэг хүлээж авах үйл ажиллагааг явууллаа.

Гэрээний дагуу үзүүлж буй үйлчилгээ нь:

- Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу шинэчилэн найруулсан хуулийн төслийн зардлын тооцооллыг боловсруулах.

Эхний тайлангуудыг ажлын хэсгийн гишүүн бүр урьдчилан танилцаж, ажлын хэсгийн уулзалт хийж, тайлангийн талаар хэлэлцэж, тайлан хэдий Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хийгдсэн хэдий ч сайжруулах шаардлагатай байсан тул санал гаргаж хүргүүлсэн. Уг санал, зөвлөмжүүдийн талаар зөвлөх

багийн ахлагч Д.Чимэддагва тэргүүнтэй цахимаар холбогдож, саналыг цахим шуудангаар зөвлөх багт албан ёсоор хүргүүлсэн.

Зөвлөх баг хүлээн авах ажлын хэсгээс өгсөн санал, хүсэлтийг хангалттай хэмжээнд тусгаж, тайлбарын хамт ирүүлсэн тул тайланг цаасаар болон цахим хувилбараар хүлээн авах нь зүйтэй гэж үзэж байна.

Үүнд:


- Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зардлын тооцооны тайлан

**Хүлээн авсан ажлын хэсэг:**

Ахлагч:

Урьдчилан мэдээлэх газрын

дарга:



Л.Оюунжаргал

2026 оны...<sup>06</sup> дугаар сарын...<sup>09</sup>ны өдөр

Гишүүд:

Улсын сүлжээний газрын Цаг уурын улсын сүлжээ

Хариуцсан ахлах мэргэжилтэн  Д.Угтахбаяр

2026 оны...<sup>06</sup> дугаар сарын...<sup>09</sup>ны өдөр

Технологи инновацын хэлтсийн Цаг уурын салбарын

технологи, инновац хариуцсан

ахлах мэргэжилтэн



Н.Энхмаа

2026 оны...<sup>06</sup> дугаар сарын...<sup>09</sup>ны өдөр

Хяналт дотоод аудитын хэлтсийн ахлах

мэргэжилтэн



Ж.Уянга

2026 оны...<sup>06</sup> дугаар сарын...<sup>09</sup>ны өдөр

Нарийн бичиг:

Захиргааны хэлтсийн Эрх зүй, гэрээ

хариуцсан ахлах мэргэжилтэн



Т.Болор-эрдэнэ

2026 оны...<sup>06</sup> дугаар сарын...<sup>09</sup>ны өдөр

**Хүлээлгэн өгсөн:**

Макро эдийн засаг ба эрүүл мэнд ТББ-н төлөөлж



Д.Чимэддагва

2026 оны...<sup>06</sup> дугаар сарын...<sup>09</sup>ны өдөр